

Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэг II Болсон бодит явдал гэж авч үзвэл...

Өмнөх нийтлэлд бид баян хүн, ядуу Лазар хоёрын тухай Есүсийн ярьсан өгүүллэгийг авч үзэж эхэлсэн. Ихэнх итгэгчид энэ өгүүллэгийг болсон явдал бөгөөд там ямар байхыг бодитойгоор хэлж өгдөг гэж ойлгодог. Ер нь энэ өгүүллэг тамын бодитойг нотлох хамгийн том баталгаа ч гэж үздэг.

Нэгэнт энэ ойлголт түгээмэл учраас бид тус өгүүллэгийг яг л бодит түүхэн явдал гэж авч хэд хэдэн талаас шинжиж үзсэн. Тухайлбал:

-Баян хүн яагаад шийтгэгдсэн, Лазар яагаад сайшаал хүртсэн бэ?

-Абрахамын өвөр гэж юу вэ?


-Дахин амилалт болоогүй байхад Лазар хэрхэн Тэнгэр дээрх улсад очсон байж болох вэ?

-Үхэгсдийн оронд хүн сэхээгүй байхад баян хүн хэрхэн тэнд тамаа үзэх боломжтой вэ?

Энэ нийтлэлд тус шинжилгээгээ үргэлжлүүлэхдээ баян хүн, Абрахам хоёрын хооронд өрнөсөн яриаг авч үзэх болно.

Баян хүн, ядуу Лазар хоёр

19 Нэгэн баян хүн байжээ. Тэр нил ягаан өнгийн нарийн нэхсэн маалинган хувцас өмсөж, өдөр бүр найрлан цэнгэдэг байв. 20 Яр шарханд баригдсан Лазар гэгч нэгэн ядуу эр хаалгыг нь сахин хэвтэж,





21 мөнөөх баяны ширээнээс унасан өвдөл цөвдлийг нь идэхсэн хэмээн хүсдэг байжээ. Хажуугаар нь ноход ирж, шархыг нь долоодог байв.

22 Ядуу эр үхсэнд тэнгэр элч нар түүнийг авч Абрахамын өвөр дээр тавьжээ. Баян нь ч үхсэнд түүнийг оршуулав.

23 Тийнхүү тэр Үхэгсдийн оронд тарчлан байхдаа хараагаа дээшлүүлж, тэртээд байгаа Абрахамыг болон түүний өвөр дэх Лазарыг харав. 24 Тэгээд тэр "Абрахам эцэг ээ, намайг өршөөгөөч. Лазарыг нааш нь явуулаач. Тэр хурууныхаа үзүүрийг усанд дүрээд хэлийг минь сэрүүцүүлэг. Би энэ галд амь тэмцэн зовж байна" гэж хашхирахад 25 Абрахам "Хүү минь, чи амьдралынхаа туршид сайн сайхан зүйлээ хүлээн авч байхад Лазар ч тэрчлэн муугаа авсныг санаач. Харин одоо тэр энд тайтгарч, чи тэнд зовж байна. 26 Энэ бүхнээс гадна, эндээс наана чинь очих, наанаас чинь энд ирэхийг хүсэгчдийн хэн ч ирж, очиж үл чадах тийм гүн ангал чи бидний дунд тогтжээ" гэхэд 27 тэр "Эцэг минь, тэгвэл түүнийг миний эцгийн гэрт илгээхийг би танаас гуйя. 28 Би таван дүүтэй. Энэхүү тарчлалын газар тэднийг ирүүлэхгүйн тулд Лазар тэдэнд сануулаг" гэж хэлжээ.

29 Харин Абрахам "Тэдэнд Мосе ба Эш үзүүлэгчид байгаа. Дүү нар чинь тэднийг сонсог" гэхэд 30 тэр "Үгүй, Абрахам эцэг минь, үхэгсдээс хэн нэг нь тэдэн рүү явбал тэд гэмших болно" гэв. 31 Харин тэр түүнд "Хэрэв тэд Мосе ба Эш үзүүлэгчдийг сонсдоггүй юм бол үхэгсдээс хэн нэг нь амилсан ч тэд үнэмшихгүй биз дээ" гэжээ гэв. (Лук 16:19-31)



Абрахам, баян хүн хоёрын хачирхалтай ярилцлага

Юуны өмнө хэлэхэд, баян хүн холын “тэртээд байгаа” (23-р ишлэл) Абрахам, Лазар хоёрыг таньсан нь гайхмаар. Тэгээд Абрахамтай яаж тийм холоос

*Боломжтой
бол шууд
утгаар нь
ойлгож ав.*

ярилцаж чадсан нь эргэлзээ төрүүлнэ. Ярьж байгаа байдал нь хүртэл үнэшилгүй байна. Бодит галд шатаж буй хүн тус баян шиг тайван ярьж чадахгүй, харин орилон хашгирч төдөлгүй ухаан алдаж үхнэ.

“Тамд орсон хүмүүс дэндүү их зовсондоо Ертөнцийн Эзэнийг үзэн ядаад байнга хараан зүхдэг” гэж заадаг пастор, теологичид байдаг нь харамсалтай. Энэ баян хүн лав тэгдэггүй, Абрахамаас хүндэтгэлтэйгээр тусламж гуйдаг. Тухайлбал: “Лазарыг нааш нь явуулаач. Тэр хурууныхаа үзүүрийг усанд дүрээд хэлийг минь сэрүүцүүлэг” гэж хүсдэг (24-р ишлэл). Гуйсан гуйлт нь их хачирхалтай санагдана. “Намайг энэ галаас гаргаад өгөөч!” гэж гуйхын оронд ганц дусал ус хүсээд байна. Хэт их тусламж гуйснаас санаа нь зовсон гэж тайлбарлах нь бий.





Гэтэл галд шатаж байхдаа хүн юу ч гуйхаас санаа зовж мэдэхээ больдог баймаар. Тэгээд ч түймэрт орсон хүнд ганцхан дусал ус яаж тус болох билээ? Тэр халуун галд дусал ус тус болохоос нааш шууд л ууршина гэж санагдана. Тэгвэл ганцхан л дусал усны төлөө хүнийг зарах хэрэг юу вэ? Мөнөөх баян яагаад галд шууд өртөж буй нүд юмуу арьснаасаа илүү аман доторх хэлийгээ чухалчилж байгаа нь ч мөн сонин.

Баян хүн яагаад Ертөнцийн Эзэнээс тусламж гуйгаагүй вэ? Үхэгсдийн оронд Абрахам давуу эрх мэдэлтэй нь биш байлтай. Сонирхолтой нь, “надаас биш, Их Эзэнээс гуй” гэх мэтээр Абрахам баян хүнийг зэмлээгүй. Өөрөө ч “За, би Их Эзэнээс гуйж өгье” гэж хэлэхгүй. Энэ дэлхийд байхдаа Абрахам Ертөнцийн Эзэнээс санаа зовсон ч Содом хотынхны төлөө ахин дахин гуйсан (Эхлэл 18). Тэр л Абрахам одоо өөрийн удмаа тарчлан зовж байхыг нүдээрээ харсан ч чулуун зүрхтэй болсон мэт тайван сууж байна гэхэд итгэмээргүй.

“Лазар амьдралдаа их зовсон, одоо тайвшрах хэрэгтэй. Харин чи амьдралдаа сайн сайхан зүйлийг авдаг байсан тул одоо зовох ёстой” гэж тайван суунгаа учирладаг. Энэ тайлбар нь ч их хачирхалтай. Баян хүнд хийсэн гэмийг нь сануулахаас илүүтэй ертөнцөд жаргасан хүн нас барсан хойно заавал зовох ээлжтэй гэсэн санааг онцлоод байгаа нь бас эргэлзээ төрүүлнэ. Гэвч энэ санаа Библийн бусад сургаалтай нийцэхгүй нь мэдээж.

Абрахам үргэлжлүүлэн нэгэн ангалын тухай ярьдаг. Тус ангал юуны өмнө галтай хэсэгт очих хүсэлтэй,



Абрахамын талд буй хүмүүсийг хорихын тулд оршдог гэдэг нь үнэхээрийн шинэвтэр санаа (26-р ишлэл)! Яахав, тамд тарчлан буй хүмүүсийг диваажингаас харах боломжтой юм бол сайхан сэтгэлт хүн хэрхэн амар тайван сууж, жаргаж чадах билээ. Тийм хэцүү байдалтай хүнд туслах гэж л тамд очих хүсэл сайн хүмүүст төрдөг байх. Гэвч хичнээн хүссэн ч тийш очих ямар ч аргагүй гэж Абрахам баталдаг. Нас барагсдыг хоёр бүлэгт салгадаг англын тухай Библийн өөр хаана ч бичигдээгүй байдаг. Дүгнэж хэлэхэд, Абрахам, баян хүн хоёрын байгаа байдал нь бодит байдалд таарахгүй гэмээр, яриа нь ч Библийн үнэнд нийцэхгүй хачирхалтай санагдаж байна.

Там ба диваажин хоёрын хооронд харилцаа холбоо бий юу?

Баян хүн, Лазар хоёрын тухай өгүүлэл үнэхээр диваажин ба тамд очсон хоёр хүний бодит түүх мөн гэж үзвэл эсрэг тэсрэг тэр хоёр газрын хооронд явж болдоггүй ч гэсэн харилцан холбоо байдаг гэсэн үг. Биднийг энэ дэлхийд дээрэлхдэг байсан томчууд тэртээ буй тамаас

Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай анзаарахад

--Энэ өгүүллэгийг **санагдуулам** өөр ямар ч ишлэл байхгүй. Өөрөөр хэлбэл, “баян хүн, ядуу Лазарын тухай ярьсан Есүсийн үгийг сана” гэж Библийн хаана ч байхгүй.

--Энэ бол эхнээсээ дуустлаа еврейчүүдийн тухай өгүүлдэг. Еврейчүүдийн хамгийн их хүндэлдэг Абрахам, Мосе, эш үзүүлэгч нар энэ өгүүллэлийн гол баатрууд. Өгүүлэгч Есүс гол баатрын дүрд байхгүй байна.

--Тамлалын газар орохгүйн тулд Мосе ба эш үзүүлэгч нарыг сонсох хэрэгтэй гэж Абрахам хэлсэн ч тэдний хэн нь ч хэзээ ч тийм газрын тухай зааж байгаагүй (28-29).

--Үхлийн тухай, Мосе ба эш үзүүлэгч нарын сургаалын дагуу нас барагсад юу ч мэдэхгүй, юу ч мэдрэхгүй, ер нь оршин байхаа больсон.

--«Хуучин Гэрээ»-нд хэзээ ч дуусашгүй зовлонгийн тухай огт дурдагдаагүй.



биднийг таньж янз бүрийн шаардлага тавих болно. Дайсан байсан хүмүүс нэг бол биднээс энэрэл, тусламж гуйж шалан, нэг бол биднийг хараан зүхсээр байх болно. Гэвч тэдэнд тусалмаар байсан ч туслах чадвар байхгүй. Тийм байвал ямар санагдах вэ? Диваажин тийм хөрштэй байхад үнэхээр жаргалтай, амар заяа үзүүлдэг орон байж чадах уу? гэж бодмоор.

Улмаар, энэ өгүүллэг болсон явдал мөн юм бол бид мөнхийн жаргалд очихдоо тэндээс тамд орсон хайртай хүнтэйгээ ч харилцах боломжтой гэсэн үг. Манай Монголд ээж хүний хайр маш алдартай. Есүст итгээгүй хүүгээ тамд тарчлан байгааг мөнхөд ажиглах, ёолохыг нь үүрд мөнх сонсох итгэгч ээж хэрхэн диваажинд жаргах вэ? Харин ч аймшигтай, хэзээ ч дуусашгүй хар дарсан зүүд мэт санагдана! Хүүхдээ шаналж байхыг харж түүнд туслах гэж юу ч хийж чадахгүй байх нь эх хүний сэтгэлд хамгийн хэцүү зовлон болохыг ээж болгон сайн мэднэ. Тамд орсон хүүхэдтэй итгэгч хүн бүрийн хувьд мөнхийн жаргал мөнхийн там болж хувирна гэхэд хэтрүүлээгүй хэрэг юм.

Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай анзаарахад (үргэлжлэл)

--«Хуучин Гэрээ»-нд нас барагсад хоорондоо харилцдаггүй.

--“Абрахамын өвөр” гэдэг хэллэг Библийн өөр хаана ч гардаггүй.

--Бүгд ялаагүй очдог Үхэгсдийн орон том ангалаар хуваагдсан тухай «Хуучин Гэрээ»-нд бичигдээгүй.

--Лазар шударга сайн хүн байсан талаар энэ өгүүллэгт гардаггүй. Мөн баян хүн ёрын муу хүн байсан эсэх талаар юу ч байхгүй.


--Энэ өгүүллэгт Лазар, баян хүн хоёрын зан төлөвийг бус, санхүүгийн байдлыг нь авч үзсэн байна (25).

--Баян хүн, Лазар хоёрын сэтгэл юмуу амин сүнсийг дурдаагүй байна.

--Хүн аврагдахын тулд өөрийнх нь төлөө загалмай дээр нас барсан Есүст итгэх ёстойн талаар нэг ч үг байхгүй.



Энэ өгүүллэгийн түгээмэл ойлголтын дагуу диваажин, там хоёр ийм ойр холбоотой боловч тамыг “Ертөнцийн Эзэнээс үүрд мөнх сална” гэж тайлбарлах нь олонтоо. Там бол “Ертөнцийн Эзэний байхгүй цорын ганц газар” гэдэг.



Гэтэл хаа сайгүй орших Ертөнцийн Эзэн ямар нэгэн газраас хэрхэн алга болох вэ? Тийм санаатай ишлэл Библийн хаана ч байхгүй. Харин ч **“ИАВЭ Би тунхаглаж байна. Миний харахааргүй газрыг олж нуугдах хэн нэгэн байна уу? ИАВЭ Би тунхаглаж байна. Би тэнгэр огторгуй, газар дэлхийг дүүргэн оршдоггүй хэрэг үү? (Иеремиа 23:24).**

Тиймээс ч **“Сайн муу гэлтгүй бүхнийг ажиж Хаа сайгүй ИАВЭгийн мэлмий тольдоно”** гэсэн үг бий (Сургаалт үгс 15:3).

Иймээс **дээрх зураг** худлаа гэсэн үг. Их Эзэн аливаа хүнийг хэзээ ч бүрмөсөн орхиж зөнд нь хаяхгүй.

“Хүмүүний замыг Бурхан тольдож байдаг. Хамаг алхмыг нь Тэрбээр харж байдаг” (Иов 34:21). Үүнд хүний хамгийн хэцүү зовлонд хийсэн алхам багтахгүй байхыг хэн хэлж зүрхлэх вэ? Үүнд муу хүмүүсийн алхам ч ордогийг үгүйсгэх хэн байна вэ?



“Таны Сүнснээс би хаашаа холдох билээ? Таны өмнөөс би хаашаа бултах билээ? ... Үхэгсдийн оронд хэвтрээ заслаа ч Та тэнд” гэсэн гайхаш төрүүлэм үгийг Давид хаан бичсэн (Дуулал 139:7-8). Үнэхээр хаа сайгүй орших Ертөнцийн Эзэн Үхэгсдийн оронд буй тэр баян хүнтэй ч хамт байна гэж ойлгогдохоос өөр аргагүй.

Тэртэй тэргүй Ертөнцийг бүтээгч Эзэнгүйгээр хэн ч амьд явахгүй, юу ч оршин тогтнох боломжгүй – **“Бид Түүний дотор амьдарч, хөдөлж, оршин тогтдог”** (Үйлс 17:28).

“Бүх юмс Түүгээр оршин тогтнодог” (Колоссай 1:17). “Бүх юмс”-ад Үхэгсдийн орон ба дотор нь буй бүх үхэгсэд хүртэл багтах нь мэдээж. Хэрэв там байдаг юм бол тамын гал дөл хүртэл Түүний хүчээр л бадарна гэсэн үг. Юм бүхнийг бүтээгээд зогсоогүй эгнэгт оршин тогтноулагч Их Эзэнээс сална гэж байхгүй.

Үхлийн тухай Мосе, эш үзүүлэгчид юу заасныг сонс

Баян хүн эцэст нь дүү нараа галын зовлонд орохгүй байхад туслахыг Абрахамаас гуйдаг. Лазарыг үхлээс амилуулахыг хүртэл түүнээс гуйдаг (энэ нь Лазар дахин амилаагүйг мөн харуулна). Гэтэл Абрахам юу ч хийхээс татгалзан, “Дүү нар чинь Мосе болон эш үзүүлэгчдийн үгийг сонсог” хэмээн хариулдаг.

Сонсох ёстой тэр үг нь тарчлалын тамд хэрхэн орохгүй байхын тухай үг баймаар байна. Гэвч «Хуучин гэрээ»-г судлахаар нас барагсад бүгд нэг л очих газартай болох нь тодорхой. Тухайлбал:



“Бүгд нэг л газар луу одно. Бүгд шорооноос бий болсон, бүгд шороондоо буцна” (Номлогчийн үгс 3:20).

Учир нь,
“Зөвт ба буруут, сайн ба муу, цэвэр ба бузар, тахил өргөдөг ба өргөдөггүй, сайн хүн ба нүгэлтэн, тангараг өргөдөг ба өргөдөггүй аль алинд нь нэг л хувь тавилан тохиодог аж.



Нарт хорвоод болж буй бүхний дунд хүн бүрд нэг л тавилан байдаг нь харуусам явдал юм... үхэл [еврей: үхэгсдэд] рүү оддог ажээ...

Чиний очих Үхэгсдийн оронд ажил үйлс, учир шалтгаан, мэдлэг ойлголт, мэргэн ухаан гэж үгүй.” (Номлогчийн үгс 9:3, 10).

Хамаг «Хуучин гэрээ»-нээс мөнхийн зовлонт тамын тухай нэг ч үг олддохгүй нь мэдүүштэй! Үхэгсдийн орон гэдэг еврей үг (H7585) «Хуучин гэрээ»-нд 64 удаа гардаг боловч хэзээ ч шийтгэл юмуу зовлонтой холбогдоогүй, үргэлж булш бунхан, эсвэл шилжсэн утгаараа үхэл буюу үхэгсдийн үхмэл байдлыг хэлнэ.



Дахин хэлэхэд, хүн болгон нас барахдаа ялгаагүй
Үхэгсдийн оронд очдог. Нас барсан байж диваажин
юмуу тамд очно гэж байхгүй гэсэн үг.

Үхэгсдэд нэг л очих газар бий. Тэр бол амьдралын
ямар ч шинж байхгүй үхлийн булш.

Үхлээр ийн “нойрсож буй” хүн бүхэн Их Эзэний
тогтоосон өдөр

“сэрж босох” буюу
үхлээс амилахдаа
л шагнал эсвэл
шийтгэл хүртэх
болно. Тэр өдрөөс
наана үхэгсэд
сэтгэлээрээ ч,
сүнсээрээ ч, өөр
ямар нэгэн
байдлаар ч амьд
байх ямар ч
боломжгүй.



Үхэл нойрсохтой адил болохыг заадаг Бичвэрүүдийн
сургаал үхлийн дараах тамын тухай Христигэлт хэдэн
янзын сургаалаас эрс өөр гэсэн үг. Теологичдын
тамын тухай уламжлалт онол ердөө л анхны өвөг
дээдсийг маань мэхэлсэн өнөө Могойны худалд
үндэслэгддэг. “Та нар зайлшгүй үхэх болно” гэж
Ертөнцийн Эзэн хэлсэн байхад (Эхлэл 2:17) Могой “та
нар үхэхГҮЙ” гэж эсрэгээр нь хэлсэн (Эхлэл 3:4). Хүн
төрөлхтөний бүх шашин, уламжлалт сургаал, мөн
сүнстэй харьцдаг хүмүүс Могойтой санаа нэгдэн, “Хүн
нас барсан ч үнэндээ үхэхгүй, амьдрал нь өөр нэгэн
байдлаар үргэлжилдэг” гэнэ.



Ийнхүү Ертөнцийн Эзэн үхлийг амьдралын эцэс гэдэг байхад хүн үхлийг өөр амьдрал руу хөтлөх үүд хаалга гэж үзнэ. Ертөнцийн Эзэн үхлийг гай гамшиг гэдэг бол хүн үхлийг ивээл гэж бодох нь бий. Ертөнцийн Эзэн үхлийг аймшигт “дайсан” гэсэн байхад (1 Коринт 15:26) үхлийг олон христчин хүмүүс “яруу жавхланта оронд хөтлөх үүд хаалга” гэж ярина. Хүнийг үхлээс



ангиржуулахыг Ертөнцийн Эзэн “энэрэл үзүүлэх”-ийг хэлнэ (Филиппой 2:27). Сонирхолтой нь, хүн үүнд санаа нэгдэж “Аюумшгийн хаан” болох үхлээс бүхий л хүчээрээ ангижрахыг хичээдэг (Иов 18:14, АБ).

Муу ёрын сүнсний худал хуурмаг дэндүү амжилттай явагдсан учраас Их Эзэн Есүс Өөрөө “Би дахин ирж та нарыг Өөртөө авна” гэж байхад (Иохан 14:3) христчин хүмүүс “*Үгүй, Их Эзээн! Та намайг гэж ирэх шаардлагагүй. Би нас бараад Тан дээр очно*” гэдэг мэт. Иймд Есүс Христийн цог жавхлантайяа буцан ирж, Өөрийн ариун хүмүүсээ үхэгсдээс амилуулах “ерөөлт найдвар” Христийн Сүм Чуулганы ухамсраас бараг л баллагдсан (Тит 2:13). Ингээд хүний уламжлал Их Эзэний амлалтыг итгэгчдийн дунд чухал биш тооцоход хүргэсэн.




Гэтэл Их Эзэн биднийг “нойрссон хүмүүсийн талаар мэдэхгүй байхыг хүсээгүй” учраас энэ талаар Паулаар дамжуулан 1 Тесалоник 4:13-18т тодорхой үг үлдээсэн. Энэ бол Ертөнцийн Эзэний онцгойлон бидэнд зориулж илчлэлээр өгсөн амлалт юм.

Есүс Өөрөө нас барж, эргэж амилсан шиг “Түүний дотор нойрссон хүмүүс” мөн “тийнхүү” дахин амилах болно (14-р ишлэл). Есүсийг ирэхэд нас барж амжаагүй итгэгчид, “нойрссон” буюу нас барсан итгэгчдээс түрүүлж Их Эзэн дээр очихгүй (15).

Хэрэв үхлийн тухай уламжлалт үзэл үнэн байсан бол Паул “Есүсийг ирэхэд бид *аль хэдийнэ Их Эзэн дээр очсон* хүмүүсийн хойно Түүн дээр очно” гэж бичих ёстой байсан. Үүнээс ч харахад үхэгсэд мөн биднээс түрүүлж Их Эзэн дээр очсон байх боломжгүй.

Харин Есүсийг ирэх тэр л өдөр юун түрүүн “Христийн дотор үхэгсэд” буюу нас барсан итгэгчид үхэгсдээс амилах болно (16). Дахин амилах нь зөвхөн үхэгсдэд хамаатай билээ. Харин нас барж амжаагүйнүүд нь “*тэдэнтэй хамт* агаар мандалд Эзэнтэй уулзахаар үүлэн дотор өргөгдөх” болно. Бид бүгд зэрэг, хамтдаа л Их Эзэн дээр очиж “тийнхүү Эзэнтэй үргэлж хамт байх болно”. “Тийнхүү” гэдэг нь “ийм арга замаар” гэсэн үг. Өөр ямар ч арга замаар бид Их Эзэн дээр очихгүй.

Үүнээс ч харахад үхэл мөнхийн жаргалд хөтлөх үүд хаалга биш. Харин Есүс шиг дахин амилж тэнгэр луу өргөгдөхөөр бид тэнгэр дээрх улсад очих болно.





Үхэгсдээс амилах тэр өдөр хүртэл нас барсан итгэгчид “нойрсдог”. Хүн Их Эзэний үгийг хичнээн их эсэргүүцсэн ч хамаагүй бид Түүний энэ үгэнд анхаарвал зохино. Эс тэгвээс “Их Эзэний үгээр” (15) бидэнд хэлсэн үнэнээс бид хоцорч “бусад хүмүүсийн адил” найдваргүй хэвээр байх болно (13).

	ХҮНИЙ үзэл бодлын дагуу	ЕРТӨНЦИЙН ЭЗЭНИЙ дагуу
	Үхэгсдийн оронд доорх зүйлс болдог (Лук 16)	Үхэгсдийн оронд юу ч болдоггүй (олон ишлэл)
Үхэгсдийн оронд болж буй явдлыг шууд утгаар ойлгох ёстой юу, шилжсэн утгаар ойлгох ёстой юу?	галын дөлд шагах (24)	тоос шороонд хэвтэх (Иов 17:16; Дуу. 30:9)
	хашгирах (24)	анир чимээ байхгүй (Дуу. 115:17)
	тарчлан байх (23)	мэдэх юм байхгүй (Ном. 9:5)
	тайвшрал хүсэх (24)	юу ч бодохгүй (Дуу. 146:4)
	холоос ч гэсэн юм харах (23)	харанхуй, гүн сүүдэртэй (Иов 10:21) нүд харанхуйлсан, аниастай (Дуу 13:3)
	учирсан, учраагүй хүнийг таних (23)	Их Эзэнийг ч дурсан санахгүй (Дуу. 6:5)
	бусадтай ярилцах (24)	юу ч ярихгүй (Дуу. 31:17; 94:17)
	өршөөл гуйх тусламж гуйх (24)	Их Эзэний найдвартайг горьдох ч үгүй (Исаиа 38:18)
	амьдралаа эргэн санах (25)	“маргалтын газар” (Дуу. 88:12), дурсамж байхгүй (Дуу. 6:5; 88:12)
	гэр бүлдээ санаа зовох (28)	хайр байхгүй (Ном. 9:6), хорсол байхгүй (Ном. 9:6), атаа жөгөө байхгүй (Ном. 9:6)
“Та нарт Мосе болон Эш үзүүлэгчид байгаа, тэднийг сонс!” --Есүс	бусдыг зовлонд орохоос аврах төлөвлөгөө гаргах (27-28)	юм сэтгэхгүй, төлөвлөгөө гаргахгүй (Ном. 9:10)
	бусадтай маргалдах (30)	мэргэн ухаан байхгүй (Ном. 9:10) ажил үйлс байхгүй (Ном. 9:10)
	бусдыг гэмшээсэй гэж хүсэх (30)	магтаж чадахгүй, талархаж чадахгүй (Дуу. 6:5; 30:9)
	амь тэмцэн зовох (24-25)	нойрсох мэт байх (Дуу. 13:3; 139:8)
	*Есүс, Ертөнцийн Эзэн, Ариун Сүнс ч огт дурдагдаагүй	*Үхэгсдийн орон Их Эзэний нүдний өмнө ил, тэнд ч гэсэн Тэрээр байдаг (Сургаалт үгс 15:11; Дуу. 139:8)
	*зовлонтой, тайтгаралтай гээд хоёр газар бий	*сайн, муу бүгд ялгаагүй Үхэгсдийн оронд явцгаана (Ном. 3:20; 6:6; 9:2)
	=> Үхэл хэцүү амьдралтай адил	=> Үхэл нойрсохтой адил (Дуу. 13:6)
	ҮХЭГСДИЙН ОРОНД ЧУХАМ ЮУ БОЛДОГ ВЭ?	



Бичвэрүүдийн тод үгээр илэрхийлсэн, Үхэгсдийн орны тухай бодит баримтыг базаад харуулсан дээрх хүснэгтийг сайтар авч үзнэ үү! Библи, Христитгэлт хоёрын сургаал зөрчих үед та чухам хэнд итгэх вэ?

Дүгнэлт: Шууд утгаар ойлгож авах нь боломжтой

Бид анх баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэгийг шууд утгаар хүлээн авч “хэрхэн баян хүний араас тамд орохоос зайлсхийгээд ядуу Лазар шиг диваажинд орох вэ?” гэсэн асуултын хариуг олох эрэлд гарсан билээ. Мэдэж авсан зүйлээ нэгтгэхээр, тус хоёр хүн *яагаад* тамд эсвэл диваажинд орсон шалтгаан нь өгөгдөөгүй. Тэгээд ч энэ хоёр яг там ба диваажинд орсон нь удалгүй эргэлзээтэй болж, эцэст нь Бичвэрүүдийн үгэнд нийцэхгүй учраас боломжгүй хэрэг болж илэрсэн.

Үхлээс дахин амилж, үхэшгүй амьдралтай болсон анхны хүн бол Есүс Христ гэдэг нь Бичвэрийн бат баримт. Есүсийн хэлснээр нэг ч хүн тэнгэр дээрх улсад очоогүй байна гэдэг нь мөн баттай үг. «Хуучин гэрээ»-ний итгэлийн баатрууд Их Эзэний амлалтыг хараахан хүртээгүй нь бодит баримт. Ертөнцийн Эзэний хүмүүсийн дахин амилах нь болоогүй нь эргэлзээгүй. Диваажин бол энэ эрин үеийн дараа л шинэчлэгдэх дэлхий дээр байх болно.





Энэ бүх бодит баримтын бат үндсэн дээрээс дүгнэхэд Абрахам, Лазар хоёр дахин амилаагүй, диваажин юмуу тэнгэр дээрх улсад очсон байх боломжгүй. Лазар нас бараад дахин амилаагүй хэрнээ бие махбодиороо “Абрахамын өвөр”-т байгаа нь ойлгомжгүй. “Абрахамын өвөр” гэдэг нь лав бодит газар биш.

Баян хүний очсон “Үхэгсдийн орон” гэж нэрлэгдсэн тамлалтын газарт хэрхэн очихгүй байхаар ганц заавар өгсөн нь «Хуучин гэрээ»-нд бичигдсэн Мосе болон эш үзүүлэгч нарын үгийг сонсох буюу итгэн дагахад оршино. «Хуучин гэрээ»-ний сургаалыг анхааралтай шинжихэд хүн нас барахдаа зайлшгүй Үхэгсдийн оронд очдог нь тодорхой болсон. Үхэгсэд бүгд ялгаагүй нэг л газар очдог гэсэн үг.



Гэтэл тэр газрын жинхэнэ нөхцөл байдал нь баян хүний тулгарснаас эрс өөр. Дээрх хүснэгтийн баруун талд нь Үхэгсдийн орны тухай эш үзүүлэгч нарын бодит баримт бүхий үгийг тавьсан. Мөнхийн гал дүрэлзэх тамын тухай тэд нэг ч үг хэлээгүй. «Хуучин гэрээ»-ны даяар “там” гэсэн үг ч алга. Үхэгсдийн орон харин ч анир чимээгүй, марталтын газар бөгөөд тэнд байгаа үхэгсэд нойрсож буй хүн мэт юу ч мэдэхгүй. Дуулал 146:4-ын дагуу хүний сүнс гарч явдаг тэр мөчид бодлууд нь мөхдөг гэдэг нь зүйрлэл биш, Бичвэрийн бодит баримт мөн. Тэгвэл үхэгсдийг үргэлжлүүлэн юм боддог гэж үзэх нь илт буруу. Үхэгсэд тархигүй байж юм бодсоор, тэр бодлуудаа



хэлгүй байж үгээр илэрхийлж, чихгүй мөртлөө бусад үхэгсдийн хариу сонсдог гэдэг бол боломжгүй хэрэг. Үхэгсдийн орон бол үхлийн булш буюу үхмэл байдлыг хэлэх нь ил. Иймд Үхэгсдийн оронд хүн тамлуулах боломжгүй. Улмаар, Ертөнцийн хаа сайгүй орших Эзэн Үхэгсдийн оронд хүртэл байдаг. Түүнээс сална гэсэн ойлголт Бичвэрүүдэд алга.

Үхэл ба Үхэгсдийн ороны тухай Мосе ба эш үзүүлэгчдийн сургаалыг бид сонсохын тулд үгсийг нь илт үгүйсгэдэг тамын тухай сургаалыг бид сонсох ёсгүй гэсэн үг биш гэж үү?

Дүгнэж хэлэхэд, баян хүн, Лазар хоёрын тухай өгүүллэгийг бодит түүх мэтээр шинжиж үзэхэд тодорхой дүр зураг илрэхийн оронд дэндүү олон тайлагдашгүй асуудал гарч ирдэг. Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэг *шууд утгаараа* үхлийн дараа юу болохыг заахгүй, харин хэт олон зөрчил бүхий асуудал үүсгэж, Библийн бусад олон хэсэгтэй таарахгүй нь тодорхой болсон. Бие махбод, амин сүнс, сэтгэл оюун, гэм, шийтгэл, үхэл, булш, Үхэгсдийн орон, сайн мэдээ, итгэл, аврал, Ертөнцийн Эзэнтэй эвлэрэх, шагнал, нигүүлсэл, зөвтгөл, эш үзүүлэгчдийн үгс, үхлээс амилах, үхэшгүй байдал гэх мэт Библийн маш олон чухал сургаалтай энэ өгүүллэг *шууд утгаараа* зөрчилддөг.





Хэрвээ бид Есүсийн ярьсан энэ өгүүллэгийг бодит түүх гэж хүлээж авбал Түүний үгийг Библийн хэдэн зуун ишлэлтэй зөрчихөд хүргэнэ. Тийм байж болохгүй нь мэдээж.¹

Их Эзэн
Өөрийн Үгээ
хэзээ ч
зөрчихгүй!

“Их Эзэн Өөрийн Үгээ хэзээ ч зөрчихгүй” гэсэн Библийн утгын

тайлал ухааны асар чухал зарчмыг бид анхаарах ёстой. Тэгвэл тус өгүүллэгийг шууд утгаар хүлээж авах нь Есүсийн үгийг гажуудуулсан хэрэг болно. Энэ замаар явах нь биднийг төөрөгдөлд оруулна гэсэн үг.

¹ Тэр ч байтугай, шинжлэх ухаан, байгалийн жамаас ч энэ өгүүллэг зөрдөг. Хүн зөвхөн бие махбодтой байж амьдарна. Биеэрээ галд шатан байхдаа хүнтэй боловсон маягаар харилцаж чадахгүй%болдоггүй нь байтугай мөнхөд шатах огт боломжгүй хэрэг. Дүрэлзсэн ямар ч гал хэзээ нэгэн цагт заавал унтарна. Байгалийг “Ертөнцийн Эзэний хоёрдахь ном” хэмээдэг нь учиртай. Байгалиараа дамжин Их Эзэн бидэнд олон зүйл ойлгуулахыг зорьдог. Тиймээс Өөрийнхөө тогтоосон байгалийн жамыг зөрчих нь маш ховор. Ер бусын замаар төрсөн Исаак, Иохан Баптист, Есүс гурвын жишээ бий. Тэдний төрөлт онцгой тохиолдол байсан учраас бидэнд их зүйл ойлгуулдаг. Гэтэл тэдний төрөлт хүртэл яг хэлэхэд байгалийн жамыг эсэргүүцсэн явдал байгаагүй. Исаак, Иохан Баптист хоёрын ээжүүд хүүхэд олоход хэт өндөр настай байхыг засах нь Их Эзэний хувьд хялбар хэрэг. Есүсийн ээж эр хүнтэй хавьтаагүй ч, хэрэгтэй эсийг бүтээж умайд нь оруулах нь ч Түүнд хэцүү хэрэг биш. Тэгээд тэр гурван ээж хүүхдээ жам ёсоор л тээгээд төрүүлсэн билээ. Нөхцөл байдлыг байгалийн жам үйлчлэх болтол зассан гэж хэлж болно. Их Эзэний хийсэн бүх гайхамшиг тийм байж магад. Байгалийн жамын тухай шинжлэх ухааны олсон мэдлэг дутмаг учраас энэ талаар баттай үг хэлэх боломжгүй. Ямартай ч, үүрд мөнх дүрэлзэх галтай тамын тухай сургаал үнэн хэрэгтээ “хүн нас барах болгонд байгалийн жам зөрчигддөг” гэж хэлэхээс өөрцгүй бөгөөд энэ бол огтхон ч үнэмшилгүй.



“Боломжтой бол шууд утгаар нь ойлгож ав” хэмээх Библийн утгыг тайлах зарчмыг дагахдаа бид энэхүү өгүүллэгийг шууд утгаар ойлгож авах нь *боломжгүй* болохыг олон талаас батлан харуулсан.

Тийм учраас баян хүн, ядуу Лазарын тухай өгүүллэг болсон явдал байх боломжгүй бөгөөд эхнээс нь дуустал *дүрслэлийн чанартай, шилжсэн утгаар ойлгогдох ёстой сургаалт зүйрлэл* мөн гэсэн дүгнэлтэд хүрлээ. Абрахам лав Есүсийн өгүүллэгт бодитоор бус, ямар нэгэн шилжсэн утгаар гардаг нь Еврей 11-ээс тодорхой. Тэгвэл ядуу Лазар, баян хүн хоёр ч ялгаагүй үлгэрийн дүр тоглосон болж таарна.

“Тамд биш, диваажин буюу мөнхийн жаргалд орохын тулд бид юу хийх ёстой вэ?” гэсэн бидний анх тавьсан асуултанд Есүсийн өгүүллэг хариу өгөхийг зориогүй нь тодорхой болсон. Түүний энэ сургаалт үлгэрийг ярьж өгсөн шалтгаан эрс өөр.

Хэрвээ бид тус үлгэрийг түүхэн явдал гэж үзсээр байвал Түүний бидэнд ойлгуулах гэсэн үнэнг эрж хайхгүйд хүрч, үнэ цэнэтэй зүйлээс хоцроод улмаар айдсанд баригдсан хэвээр байх болно **%байж мэднэ**. □



Библийн ямар ч хэсгийг зөв ойлгохын тулд хам сэдэвт нь авч үзэх ёстой гэсэн зарчим нэн чухал. Иймд бид дараагийн нийтлэлд баян хүн, ядуу Лазар хоёрын тухай сургаалт зүйрлэлийн хам сэдвийг авч үзэх болно.



Ашигласан эх сурвалж:

- Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.
- Brown, C. (1975). The New International Dictionary of New Testament Theology.
- Bullinger, E. W. (1902). The Rich Man and Lazarus: An Intermediate State? <http://www.biblical-data.org/LAZARUS.pdf> -оос олсон.
- Dawson, S. G. (1943). The rich man, Lazarus, and the afterlife. www.truthaccordingtoscripture.com -оос олсон.
- Eby, J. P. (n.d.). Abraham's bosom: A treatment of the parable of the rich man and Lazarus. <https://godfire.net/eby/abrahams.html> -оос олсон.
- Froom, L. E. (1966). Gravity of Ascribing False Teachings to Christ. www.truthaccordingtoscripture.com -оос олсон.
- Gill, John (1690-1771). Exposition of the Entire Bible. www.biblehub.com хэмээх сайтаас олсон.
- Huie, B. T. (1998). Lazarus and the rich man. www.tentmaker.org -оос олсон.
- Leiter, S.Y. (2003). Grasping the Heel of Esau. www.chabad.org хэмээх сайтаас олсон.
- Martin, E. L. (2003). The real meaning of Lazarus and the rich man. <http://www.what-the-hell-is-hell.com/HellArticles/RichManParable.htm> -оос олсон.
- Smith, L. R. (n.d.). Lazarus and the Rich Man: A scriptural journey through the intriguing parable of Lazarus and the rich man. www.bible-truths.com -оос олсон.
- Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.
- Patching, J. The rich man and Lazarus. <http://www.tentmaker.org/books/RichManandLazarus-Patching.html> -оос олсон.
- Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org хэмээх сайтаас олсон.



Баян хүн, ядуу Лазар хоёрын тухай өгүүллэг • 20

-Wilson, Larry (2007). The rich man and Lazarus. Wake up America Seminars. www.wake-up.org -оос олсон.

-Witherell, J. F. (1843). Rich man and Lazarus. In *Five Pillars in the temple of partialism removed*. Concord: Balm of Gilead.